

БАТЛАВ.
САНГИЙН САЙД

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН
ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН
САЙД

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

Н.УЧРАЛ

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Л.МӨНХБААТАР

“ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гэж, мөн хэсгийн 7 дахь заалтад “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах,” гэж заасан.

Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтад “Засгийн газрын зээллэг, Засгийн газрын өрийн баталгааг Улсын Их Хурлаас, орон нутгийн зээллэгийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж байх,” гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлт төвтэй хөгжил зорилтын хүрээнд “дагуул хот, тосгоныг холбосон хурдны замтай болно.” гэж, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.9 дэх заалтад

“Улаанбаатар хотын хурдны тойрог замын дагуу “Соёл, урлагийн цогцолбор”, Монгол багт бүжгэн жүжгийн театр байгуулах, энэ төрлийн бүжгэн жүжгийн цомнол, бүтээлүүд бий болгох, урлагийн сургалт, уран бүтээлийг үндэсний өв, соёлд түшиглэн орчин цагийн бүтээл хөгжүүлэх, судалгааны инкубатор төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.” гэж тодорхойлсон.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.5.4-т “Олон улсын чанартай 88 км “Шинэ тойрог зам”, Туулын хурдны авто замыг барьж, ачаа тээврийн хөдөлгөөнийг хотын гадуур тойруулна.” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 257 дугаар тогтоолоор “Нийслэл Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх “Нэгдүгээр тойрог зам” төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн 15 хувь болох 497.1 (дөрвөн зуун ерэн долоон тэрбум нэг зуун сая) тэрбум төгрөгийг зохих хуваарийн дагуу төвлөрүүлсэн эх үүсвэрээс холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүжүүлэх, “Нэгдүгээр тойрог зам” төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 2,817.2 (хоёр их наяд найман зуун арван долоон тэрбум хоёр зуун сая) тэрбум төгрөгийн зардалд Засгийн газрын өрийн баталгаа гаргуулахаар тусгасан болно.

1.2. Практик шаардлага

Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачаалал сүүлийн жилүүдэд огцом нэмэгдсэн. Сүүлийн 10 жилд нийслэл дэх бүртгэлтэй автомашины тоо 80 хувиар өссөн бол хотын замын сүлжээ 19 хувиар тэлсэн нь замын хүчин чадал эрс дутагдахад хүргээд байна. Нийслэл Улаанбаатар хотод өдөр тутам 580-680 мянга орчим тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцдог нь одоо байгаа замуудын хүчин чадлаас хоёр дахин их ачаалалтай байна. Үүний үр дүнд замын түгжрэл нийслэл Улаанбаатар хотод хүнд түвшинд хүрч, оргил цагуудад автомашины дундаж хурд 7-13 км/цаг болсон бөгөөд хот даяар түгжрэлийн шугаман урт нийт 97 км-т хүрдэг гэсэн судалгаа байна.

Энэхүү нөхцөлд тойрог замын шинэ сүлжээ байгуулж, хотын төвийг тойруулан тээврийн урсгалыг дамжуулах нь түгжрэлийг бууруулах гол шийдэл ба ЖАЙКА олон улсын байгууллагаас 2022 онд хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын түгжрэлийн нэг үндсэн шалтгаан нь зам хоорондын холбоос дутмаг, сүлжээ тасралттай байдал гэж дүгнэсэн байдаг.

Тухайлбал, хотод бүрэн гүйцэд тойрсон хурдны зам байхгүй, гол чиглэлүүдийн зам уулзварууд хотын төвд огтлолцож байгаа нь ачааллыг төвлөрүүлэхэд хүргэдэг. Иймд шинэ тойрог хурдны зам барьснаар авто урсгал хотын зах хэсгээр шууд холбогдож, төвийн дүүргүүдийн хөдөлгөөний ачаалал мэдэгдэхүйц буурах нөхцөл бүрдэнэ гэж тооцоолж байна. Судалгаагаар замын

сүлжээг өргөтгөн, шинэ замуудыг нэвтрүүлснээр гол гудамжнуудын түгжрэл дунджаар 20 хувиар буурах боломжтой гэж гарсан байна.

Шинэ тойрог авто зам нь зөвхөн хот доторх хөдөлгөөнийг зохицуулаад зогсохгүй нийслэл орчмын бүс нутгийн хөгжил, авто замын сүлжээг өргөжүүлэх стратегийн ач холбогдолтой. Тус зам нь Улаанбаатар хот руу чиглэсэн улс, орон нутгийн гол замуудыг захад нь холбох тул хотоос хотоор дайран өнгөрдөг урсгалыг сааруулж, орон нутгийн тээвэр хотын гудамжаар дамжин түгжрэл үүсгэдэг байдлыг зогсооно. Тухайлбал, Нэгдүгээр тойрог замын трассыг төлөвлөхдөө баруун хойд зүгт Дархан-Уул аймаг руу гарах зам, зүүн урд зүгт Налайх, Чойр чиглэлийн зам, урд талд Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал руу чиглэсэн хурдны замтай тус тус холбохоор тусгасан байна.

Төслийн нийт төсөвт өртөг 918.6 сая ам.доллар бөгөөд 85 хувьд Засгийн газрын өрийн баталгаа гаргуулсны үндсэн дээр зээллэг хийх, 15 хувийг Эрдэнэс Таван толгой ХХК бүрдүүлэхээр тооцож байна. Замын нийт урт 24.8 км бөгөөд 6 эгнээ зорчих хэсэгтэй, гүүр 8.4 км, туннел 4.7 км, зам 13.7 км тус тус байхаар төлөвлөсөн.

Санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд урьдчилсан тооцоогоор барилга угсралтын ажил 2025 оны 12 сард эхэлж 2 жил үргэлжлэхээр тооцоолж байна. Төсөл ашиглалтад орж иргэд зорчих боломжтой хугацааг 2028 оны 01 сар гэж тооцоолж байна. Тойрог замаар өдөрт дунджаар 183,000 автомашин зорчихоор төлөвлөж автомашины моторын багтаамжаас шалтгаалж дунджаар 5,000.0 төгрөгийн тарифын төлбөр авахаар тооцоход жилийн 334.0 тэрбум төгрөг төвлөрнө. Техник, эдийн засгийн үндэслэлээр жил бүр авто замын нягтаршил 5 хувиар нэмэгдэхээр, замын сангийн орлогын 30 хувийг зээлийн эргэн төлөлтөд зарцуулахаар тооцож 46.4 тэрбум төгрөг нэмэгдэж 380.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр 2028 оноос төвлөрөхөөр байна.

Төслийн санхүүжилтийн хувьд “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨАТҮГ-аас 2025-2027 оны хооронд нийт төсөвт өртгийн 85 хувь буюу 780.8 сая ам.долларын зээл авахаар төлөвлөсөн. Үүнийг Монголбанкны 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн ханш 3,580 төгрөгөөр тооцоход нийт 3,802.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Энэхүү зээллэгийн хөрөнгөөс 2025 онд 260.3 сая ам.долларыг авч ашиглах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд тус эх үүсвэрийн 85 хувьд Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлтийг ирүүлээд байна. Ийнхүү Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах нь зээллэгийн нөхцөлийг сайжруулах, цаашлаад хөрөнгө оруулагчдын итгэлийг өсгөж, зээл авах боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Нэгдүгээр тойрог замыг 2028 оноос ашиглаж эхлэхээр тооцсон ба эхний 2 жилд үндсэн төлбөр төлөхгүй 2028 оноос нийт үндсэн болон хүүгийн төлбөр /ханшийн өөрчлөлтийг жил бүр 8 хувь өсгөж тооцсон/ 75.4 сая ам.доллар төлөхөөр байна. Ийнхүү төслийн ашигт ажиллагааны үзүүлэлт болох дотоод үр өгөөжийн түвшин 8.27 хувь, цэвэр өнөөгийн үнэ цэн 236.8 сая ам.доллар, зээллэгийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 12.2 жилтэй тэнцэж байна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 2 заалттай байна. Нэгдүгээр заалтад Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилтын хүрээнд “Нэгдүгээр тойрог зам” төслийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх зорилгоор 260.3 сая ам.долларын хэмжээтэй зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөрийн 85 хувь хүртэлх хэмжээнд “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨАТҮГ-т 2025 оны төсвийн жилд багтаан Засгийн газрын өрийн баталгаа гаргахад зөвшөөрөл олгох асуудлыг, Хоёрдугаар заалтад тогтоолыг дагаж мөрдөх хугацааг зохицуулна.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Тогтоолын төсөл батлагдсанаар замын хөдөлгөөний түгжрэлд алдаж байгаа цаг хугацаанаас үүдэлтэй нийгэм эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгана.

Хотын хөдөлгөөний ачаалал, түгжрэл-Шинэ тойрог хурдны зам барьснаар авто урсгал хотын зах хэсгээр шууд холбогдож, төвийн дүүргүүдийн хөдөлгөөний ачаалал мэдэгдэхүйц буурах нөхцөл бүрдэнэ гэж тооцоолж байна. Албан судалгаагаар замын сүлжээг өргөтгөн, шинэ замуудыг нэвтрүүлснээр гол гудамжнуудын түгжрэл дунджаар 20 хувиар буурах боломжтой.

Агаарын бохирдол-Шинэ тойрог авто зам төсөл хэрэгжсэнээр хотын доторх замын саатал багасаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дундаж хурд нэмэгдэх учраас хөдөлгүүрийн хоосон ажиллах хугацаа буурч, утаа, хий ялгаруулалт тодорхой хувиар буурах эерэг нөлөөтэй. Албан тооцоогоор энэ зам ашиглалтад орсноор замын хөдөлгөөний дундаж хурд 23.3 хувиар өсөх тул тээврийн хэрэгслүүдийн шатахуун зарцуулалт, агаарт цацах бохирдуулагч бодисын ялгаралт төдий хэмжээтэй буурах боломжтой гэж үзэж байгаа бөгөөд тус зам нь хотын төвийн авто ачааллыг гадагш шилжүүлэхийн зэрэгцээ нийтийн тээврийн хурд, найдвартай ажиллагааг дээшлүүлэх замаар хувийн тээврийн хэрэглээг бууруулах бодлогод дэмжлэг болно гэж төлөвлөж байна.

Зам тээврийн осол, аюулгүй байдал-Замын хөдөлгөөний түгжрэл их, замын сүлжээний нэвтрүүлэх чадвар муу байх нь зам тээврийн осол гарах нэг хүчин зүйл болдог ба улсын хэмжээнд бүртгэгдэж буй зам тээврийн ослын дийлэнх нь нийслэл хотод гардаг. Нэгдүгээр тойрог замын төсөл нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд хувь нэмэр үзүүлнэ гэж үзэж байгаа ба энэхүү зам нь олон эгнээтэй, уулзвар огтлолцол цөөн, орчин үеийн хурдны замын стандарт бүхий байх тул жолооч зорьсон газартаа гэр хорооллын нарийн гудамж, төвийн замаар тойрохгүй, илүү зохион байгуулалттай замаар хурдан шуурхай хүрэх боломжтой болно. Ингэснээр хотын доторх замууд дээрх хэт бөөгнөрөл тайлагдаж, уулзварууд дахь түгжрэл буурснаар хөдөлгөөн зохицуулалт сайжирч, осол гарах эрсдэл буурах нөхцөл бүрдэнэ.

Дэд бүтцийн хоцрогдол, замын сүлжээний дутагдал-Тойрог зам байгуулснаар хотын зүүн, баруун, хойд зүгийн алслагдсан дүүргүүд хооронд шууд холбогдох боломжтой болж, заавал төвөөр дайрах шаардлагагүй болсноор дэд бүтцийн сүлжээний тэнцвэртэй байдал сайжирна. Мөн хотын төвийн замуудад хэт ачаалал өгдөг байсан хөдөлгөөн тойрог зам руу шилжих тул одоо байгаа дэд бүтцийн ашиглалт уртсаж, засвар үйлчилгээний давтамж багасах эдийн засгийн ашигтай. Шинэ зам нь инженерийн шугам сүлжээ, геологийн нөхцөл зэргийг нарийвчлан судалсны үндсэн дээр баригдах тул урьд өмнө инфраструктур дутмаг байсан хотын захын хэсгүүдэд шинэ дэд бүтцийн суурь тавигдаж, цаашдын хөгжилд түлхэц үзүүлнэ.

Эдийн засгийн үр нөлөө-Төслийн техник, эдийн засгийн үндэслэлд туссаны дагуу тус зам ашиглалтад орсноор нийслэлийн замын хөдөлгөөний дундаж хурд 23.3 хувиар нэмэгдэнэ гэж тооцоолж байна. Энэ нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн өдөр тутам замд алдаж буй цаг хугацааг бууруулж, хөдөлмөр бүтээмжийг нэмэгдүүлэх чухал үзүүлэлт юм. Тухайлбал, өнөөдрийн нөхцөлд жолооч түгжрэлээс болж 1 цагт туулдаг багахан зайг хойшид 45 минут эсвэл түүнээс бага хугацаанд туулах боломжтой болж, үлдсэн хугацааг үйлдвэрлэл, үйлчилгээ, амьдралд зарцуулах боломжтой болох юм. Мөн хөдөлгүүрийн шатахуун зарцуулалт багассанаар импортын түлшний зарцуулалтад эерэг нөлөө үзүүлж, улсын хэмжээнд валютын зарцуулалтыг бууруулахад хүртэл хувь нэмэр оруулна.

Нийгмийн үр нөлөө-Төслийн хүрээнд байгуулах шинэ зам нь зөвхөн тээврийн хэрэгслийн хурд, багтаамжийг нэмээд зогсохгүй орчин үеийн хот төлөвлөлтийн шийдлүүдийг тусгаснаар нийгмийн эерэг өөрчлөлт авчирна. Тухайлбал, дагуул замын дагуу явган хүний зам, унадаг дугуйн зам, ногоон зурвас, гэрэлтүүлэг, хяналтын камеруудыг цогцоор нь шийдэж өгөх юм. Ингэснээр хотын захын хэсгүүдийн оршин суугчид зөвхөн автомашинаар зорчихоос өөр сонголтгүй байсан байдал өөрчлөгдөж, дугуй унах, явган алхах боломж нэмэгдэнэ. Энэ нь иргэдийн эрүүл мэнд, хотын соёлд эергээр нөлөөлнө гэж үзэж байна.

Байгаль орчны нөлөө-Нэгдүгээр тойрог зам нь дээр дурдсанчлан хотын төвийн түгжрэлийг сааруулж, тээврийн хэрэгслийн хурдыг нэмэгдүүлэх замаар автомашин тус бүрийн ялгаруулдаг бохирдуулагчийг бууруулах нэг хүчин зүйл болно. Ид түгжрэлтэй үеэр автомашинууд зогсонги байдалд удаан асаж, их хэмжээний утаа, хорт хий (SO_2 , NO_x , $\text{PM}_{2.5}$ г.м) ялгаруулдаг бол хөдөлгөөн жигд, саадгүй болсон нөхцөлд эдгээр ялгаралт мэдэгдэхүйц багасна.

Хот байгуулалтын төлөвлөгөө-Шинэ тойрог авто зам төсөл нь нийслэл хотын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдсан, төр засгийн албан ёсны баримт бичгүүдэд тусгагдсан төслийн нэг юм. Тухайлбал, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд ("Улаанбаатар-2040") хотыг олон төвт хэлбэрээр хөгжүүлэх, шинэ дэд төвүүд бий болгох бодлогын хүрээнд шинэ тойрог хурдны замыг байгуулахаар төлөвлөөд байна.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх

зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаарх санал

Тогтоолыг төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцнэ. Тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

--- оОо ---